

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны
 2023 оны 12 сарын 08 өдрийн
 339 албан бичгийн хавсралт

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2023 ОНЫ
 12 ДУГААР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хийгдэх ажил	Хүрэх үр дүн	Хугацаа	Биелэлт
1	Хугацаатай мэдээ, тайлан гаргах	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг	дараа сарын 02-ны дотор	Тайлант хугацаанд манай байгууллагад 222,318.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 204,044.1 мянган төгрөгийг зарцуулж 18,274.4 мянган төгрөг хэмнэсэн.
		Шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах	Дараа сарын 08-ны дотор	Тайлант хугацаанд оруулбал зохих 13 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулсан.
		Нийгмийн даатгалын тайлан гаргаж, хүргүүлэх	Дараа сарын 05-ны дотор	11-р сарын НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд илгээж, тайлагнасан.
2	Санхүүгийн төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	Хяналт шалгалтын үр дүн	12 сар	Санхүүгийн хяналт шалгалтыг төлөвлөгөөт 14, төлөвлөгөөт бус 9 байгууллагад нийт 24 байгууллагад хийж 5.154.552,1 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 12.016,8 мянган төгрөгийг улсын төсвийн орлого болгуулахаар, 28.060,8 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар, 7.100,2 мянган төгрөгийг хувь хүнд нь буцаан олгуулахаар нийт 47.177,8 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоосон. Үр дүн: Актын барагдуулалт 58 хувь.
3	Шивээговь сумын орон нутаг хөгжлийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх	Сангийн үйл ажиллагаа сайжирна	12 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Шивээговь сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2022-2023.08 сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 3 албан шаардлага 1190,1 мянган төгрөгийн 1 акт, нийт 986,231.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

4	Баянтал сумын Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх	Сангийн үйл ажиллагаа сайжирна	12 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Шивээговь сумын хоршоо хөгжүүлэх сангийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалт 70 хувьтай үргэлжилж байна.
5	Сүмбэр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх	Сангийн үйл ажиллагаа сайжирна	12 сар	Шалгалтыг зогсоож дүгнэлт гаргахаас татгалзсан.
6	Сум дундын ойн ангийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна.	12 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сум дундын ойн ангийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалт 30 хувьтай үргэлжилж байна.
7	Сүмбэр сумын ерөнхий боловсролын лаборатори 5 дугаар сургуулийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	12 сард	Дотоод аудитаар ерөнхий боловсролын лаборатори 5 дугаар сургуулийн үйл ажиллагааг "Дунд" эрсдэлтэй буюу "Сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлтийг өгсөн. Засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь "давтамжтай буюу 2-р түвшин"-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн 10 асуудлын 7 буюу 70 хувь нь "нөлөө ихтэй" гэж үзсэн бөгөөд шалгалтаар илэрсэн зөрчлийн хүрээнд тус байгууллагад 19 заалт, Боловсрол шинжлэх ухааны газарт 1 заалт нийт 20 заалт бүхий хугацаатай зөвлөмж өгсөн. Зөвлөмжийн биелэлт тооцох хугацаа болоогүй байна.
8	Дотоод аудит хийгдсэн байгууллагуудын зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	12 сар	Дотоод аудитаар илэрсэн 75 дутагдалд нийт 153 заалттай 6 хугацаатай зөвлөмж өгсөн. 4 байгууллагын зөвлөмжийн хэрэгжилт 80 хувьтай байна. 1 зөвлөмжийн биелэлт тооцох хугацаа болсон ч биелэлт ирүүлээгүй. 22 заалт бүхий 1 зөвлөмжийн хариу ирүүлэх хугацаа болоогүй байна.
9	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдах	12 сар	Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 43

				байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 11 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдалд хяналт шалгалт хийсэн бөгөөд хуулийн хэрэгжилт 87,3 хувьтай байна. Энэ нь өмнөх сараас 10.6 хувиар буурчээ.
10	Мэдээллийн ил тод байдлыг хангах	Мэдээллийн ил тод байдал хангагдах	12 сар	Мэдээллийн ил тод байдлыг хангаж, ойлгомжтой байлгах үүднээс байгууллагын веб хуудас болон самбарт 4 мэдээ мэдээллийг байршуулсан. Байгууллагын facebook хуудс https://www.facebook.com/profile.php?id=100090091147081/ -аар 38 мэдээллийг иргэд олон нийтэд түгээж ажиллалаа.
11	Бусад ажил	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна.	12 сар	Аймгийн удирдах ажилчдын шуурхай зөвлөгөөний 2 удаагийн хурлаас өгсөн 2 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээ"-ний хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр аймгийн Засаг даргын Тамгын газраас Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулсан "Төрийн албан хаагчдын нэгдсэн сургалт"-д 6 албан хаагч хамрагдсан. Монгол улсын төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзоригоор ахлуулсан ажлын хэсэг Төрийн албаны тухай хууль, төрийн албаны шинэтгэл, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлах сургалт, Төрийн албаны зөвлөлийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, орон нутгийн зарим төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж үүрэг чиглэл, зөвлөмж өгөх зорилгоор Говьсүмбэр аймагт 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр ажилласан. Уулзалт, сургалтад албаны дарга Н.Алтанцэцэг хамрагдсан.

				Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн уулзалтад байгууллагаас 3 албан хаагч хамрагдсан.
				Дотоод аудитын хороонд 6 шалгалтын дүнг танилцуулсан.
				Авилгын эсрэг төдөвлөгөөний биелэлтийг гарган АЗДТГ-т хүргүүлсэн.
				Байгууллагын 2023 оны өргөдөл, гомдолын мэдээ гаргаж АЗДТГ-т хүргүүлсэн.
				Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг холбогдох журмын дагуу дүгнэсэн.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Дотоод аудитор:



Л.Эрдэнэчимэг